



ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙ, САЛБАРЫН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2023 он

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙ, ХАРИУ ТАЙЛБАР ӨГӨХ ЭРХ





ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙ, ХАРИУ ТАЙЛБАР ӨГӨХ ЭРХ

Сэтгүүлчийн ёс зүй гэж юу вэ?

Ёс зүй бол юмны зайлшгүй зүй тогтол жам тавилан хэмээн Л.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар тольд тайлбарлажээ. Түүхэн үүднээс ёс зүйг товчхон тайлбарлавал МЭӨ IV зуунд Аристотел ёс зүйг “хүний үйлийн суурь номлол” гэж авч үзсэн байдаг. Гүн ухааны үндсэн бөгөөд үргэлж маргаантай байдаг сэдэв бол ёс зүй юм. Учир нь ард түмний зан заншил, аж байдал, түүх, соёл, шашин, хүний өссөн орчин зэргээс шалтгаалан хүмүүс ёс зүйг өнөөдөр ч өөрийнхөөрөө ойлгон тайлбарлахыг оролдсоор буй. Иймээс энэхүү гарын авлагад ёс зүйг гүн ухааны үүднээс тайлбарлахыг үүгээр хязгаарлаж байна. Харин ёс зүй нь нийгмийн түгээмэл зүй тогтолд захирагддаг, зарим салбарт хамт олны гишүүн бүр тодорхой ёс зүйн хариуцлагатай байснаар мэргэжлийн ажил үйлээ хийж гүйцэтгэх боломжтой болдог. Тухайлбал, “сэтгүүлч” мэргэжлийн хувьд ёс зүйтэй байх асуудал бүр чухал юм. Учир нь хэвлэл мэдээллийн салбар нийгмийн өмнө онцгой үүрэг гүйцэтгэж, тэр хэрээрээ хариуцлага хүлээдэг. Засаглал хуваах онолоор нийгмийн биеэ даасан засаглалын салбарт хэвлэл мэдээллийг албан ёсоор тооцдоггүй. Гэвч “Дөрөв дэх засаглал” гэгддэг энэ салбар нь бодит байдалд нийцсэн мэдээллийг олон нийтийн ашиг сонирхлын өмнөөс нягтлан түгээснээр нийгмийн хөгжил, сайн сайхны төлөө “Хоточ банхар” байж, эрх мэдэл бүхий хүмүүсийн үйлдлийг хянах, эгэх хариуцлагыг нэхэх, эрэн сурвалжлах, бусармаг зүйлийг илчлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх гэх мэтээр засаглалын үүрэг нь даян дэлхий даяар улам даяарчлагдсаар байна.

Энэ хэрээр хөгжлийн сэтгүүл зүй, дата сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүй, сошиал сэтгүүл зүй гэх мэтээр олон чиглэлээр сүүлийн үед эрчимтэй хөгжиж буй хамгийн даяарчлагдсан салбарын нэг болох хэвлэл мэдээллийн салбарыг өндөр хариуцлагатайгаар хөгжүүлэхэд сэтгүүлч бүр, хэвлэл мэдээллийн ажилтан бүр мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй байдаг юм.

Сэтгүүл зүйн салбарын анхны мэргэжлийн ёс зүйн дүрмийг Америкийн сонины эрхлэгчдийн нийгэмлэг 1923 онд “Үлгэр жишээч сонин хэвлэлийн эрмэлзвэл зохих зарчим”-ыг баталсан нь орчин үеийн Хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн анхны дүрэм хэмээн судлаачид үздэг. Уг зарчимд олон нийтийн ашигт сонирхолд үйлчлэхийн тулд хараат бус, шударга, итгэл үнэмшилтэй, няхуур нямбай байх зэрэг мөрдлөгийг онцгойлон тусгасан байдаг. 1920-1930-аад онд дэлхийн томоохон мэдээллийн хэрэгслүүд өөрийн ёс зүйн дүрэмтэй болсон боловч эдгээр нь төдийлөн үр дүнтэй



хэрэгжиж чадаагүй. Учир нь эдгээр он жилүүдэд ёс зүйн хэм хэмжээг сахиулан хэрэгжүүлэх бие даасан байгууллага буюу “Хэвлэл мэдээллийн зөвлөл” үгүйлэгдэж байв. Харин 1940-д оноос хойш сэтгүүлчдийг нэгтгэсэн мэргэжлийн холбоод бий болсноор сэтгүүл зүйд ёс зүйг нэхэх, мөрдүүлэх, хариуцлага тооцох байдал жигдэрсэн гэж хэлж болно. Тухайлбал,

- 1946 онд байгуулагдсан Прагад төвтэй Олон улсын сэтгүүлчдийн байгууллага (International Organization of Journalists) ёс зүйн зарчмаа хэлэлцэж баталсан.
- Брюссельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн холбоо (International Federation of Journalists) нь 1954 онд Сэтгүүлчдийн ёс зүйн зарчмуудын талаарх ОУСХ-ын тунхаглалыг (Бордоугийн тунхаглал) баталсан.
- Кайрт төвтэй Арабын сэтгүүлчдийн холбоо (Federation of Arab Journalists) – 1972 онд Араб ёс зүйн дүрэм баталсан.
- Мексикт төвтэй Латин америкийн сэтгүүлчдийн холбоо (Federación Latinoamericana de Periodistas) 1976 онд байгуулагдаад арваад жилийн дараа буюу 1980-д оны дундуур ёс зүйн дүрмээ баталсан.
- Манилад төвтэй АСЕАН-ы сэтгүүлчдийн нэгдсэн холбоо (Confederation of ASEAN Journalists, CAJ) – АСЕАН-ы сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийг 1987 онд баталсан.
- 1971 онд Европын холбооны гишүүн орнуудын сэтгүүл зүйн үйлдвэрчний эвлэлүүд Мюнхений дүрмийг (Charta von München) баталсан нь ОУСХ-с хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

Өнөөдөр бүс нутгийн болон олон улсын сэтгүүлчдийн холбооноос гадна сэтгүүл зүйн чиглэлээр байгуулагдсан сайн дурын холбоо, нийгэмлэгүүд хүртэл (шинжлэх ухааны сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүй г.м.) өөрсдийн гишүүдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, зарчмыг батлан ажиллаж байна.

Өнөөдөр дэлхийн ихэнх улс оронд үндэсний хэмжээнд Хэвлэл мэдээллийн зөвлөл (Press Council, Media Council)-үүд ажиллаж байна. Тэдгээр үндэсний байгууллагуудын ихэнх нь сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг сэтгүүл зүйн бүтээл дээр нь мөрдүүлэх, сэтгүүлчдийг мэргэжлийн алдаа гаргахаас хамгаалах, сэтгүүлчийн нэрээр ирүүлсэн гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийдвэрлэхийг зорьдог байна.

Ёс зүй бол тухайн ард түмний зан заншил, өдөр тутмын харилцааг зохицуулах “бичигдээгүй хууль” маягтайгаар тогтсон хариуцлагын хэм хэмжээ гэж ойлгож болно. Түүнтэй адилаар мэргэжлийн ёс зүйн зарчмыг тодорхойлбол,



тухайн мэргэжлийн ёс зүйг үндсэн үзэл, санаануудыг хураангуйлан базсан, мэргэжлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд чиглэсэн, дагаж мөрдвөл зохих мөрдлөгө, зөвлөмж юм. Ёс зүйн дүрэм журмыг хуульчилдаггүй, бүлэг хүмүүс үүрэг хариуцлагаа ухамсарласны үндсэн дээр чандлан мөрдөхийн тулд хүлээн зөвшөөрч баталдаг юм.

Ёс зүйн зарчмыг мөрдөхийн үр өгөөж

Сэтгүүлч ёс зүйн зарчмыг сэтгүүл зүйн бүтээлээ боловсруулж түгээхдээ мөрдөж ажиллах нь мэргэжлийн хувьд дараах ач холбогдолтой юм.

Олон улсад мөрдөгдөж буй ёс зүйн зарчим, дүрэмд байдаг хамгийн түгээмэл мөрдлөгө нь бодит байдалд нийцсэн мэдээллийг түгээхийн тулд мэдээллээ нягталж шалгадаг байх, эх сурвалжаа ил тодоор зарладаг байхыг чухалчилж байна. Ялангуяа нийгмийн сүлжээ илүү хөгжихийн хэрээр худал мэдээлэл олширч, хүмүүсийн амьдралын чухал үедээ гаргах шийдвэрт нөлөөлөх байдал сүүлийн арваад жил ихсэх болсон. Түүгээр ч зогсохгүй зарим тохиолдолд сэтгүүлчид хүртэл баталгаагүй эх сурвалжаас ташаа мэдээллийг дамжуулж түгээх болжээ. Энэ нь сэтгүүлчид хэзээ хэзээнээс илүүтэйгээр олж авсан бүх мэдээллээсээ үнэнийг эрэлхийлэх, баримт нягталж шалгах, нягт нямбай ажиллах хариуцлагатай болж байгаа хэрэг. Тэгвэл ёс зүйн мөрдлөгөө байнга санаж хэрэгжүүлэх нь дээрх хариуцлагатай зарчмаа биелүүлэх эхний боломж юм. Гэхдээ мэдээллээ эх сурвалжтай нь нягталж шалгах нь орчин цагт ихээхэн ур чадвар шаардах болсон. Наад зах нь худал мэдээллийг таних, түүнийг нягтлан шалгахын тулд цахим нягталгаа, хэрэгслүүдийг эзэмших ур чадвартай байж, маш олон төрлийн цахим талбар дээр ажиллах хэрэгтэй болж байна. Тиймээс ёс зүйн зарчмыг мөрдөнө гэдэг нь ур чадварт суралцах, мэргэжлийн арга зүйгээ сайжруулах чухал хөшүүрэг билээ.

Нөгөө талаар ёс зүйн зарчмыг мөрдөж ажилласан сэтгүүл зүйн бүтээлд мэргэжлийн ямар ч алдаа гардаггүй. Ингэснээр цагдаа, шүүхэд дуудагдаж байцаагдах, хуулийн шийтгэл хүлээх, зөрчлийн хэргээр торгуулж санхүүгийн алдагдал хүлээхээс эхлээд эрүүгийн гэмт хэрэгтэн болох улмаар аюулгүй байдлын эрсдэлд өртөх гэх мэт сэтгүүлчдэд түгээмэл тохиолддог бэрхшээлээс өөрийгөө хамгаалж чадах юм. Тийм ч учраас сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, зарчим бол сэтгүүлчийг аливаа эрсдлээс хамгаалдаг бамбай нь юм. Тиймээс дээд зэргийн ур чадвар бүхий сэтгүүлчид л ёс зүйгээ баримталж, мэргэжлийн үнэт зүйлтэй ажилладаг.



Ёс зүйн зарчим юуг агуулдаг вэ?

Олон улсын сэтгүүлчдийн байгууллагууд, тэдгээрийн ёс зүйн дүрмийн нийтлэг агуулга дараах үнэт зүйлийг илтгэж байна.

1. Ардчилсан хэвлэл мэдээллийн чухал үнэт зүйл нь хараат бус оршин тогтноход байдаг. Хараат бус байдлыг алдагдуулдаг дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөнөөс ангид байх зарчмыг сэтгүүлчийн ёс зүйн дүрэмд үүрэгжүүлсэн байдаг. Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн зарчимд далд хэлбэрийн нөлөөллийн бүтээлд сэтгүүл зүйн төрөл, хэлбэрийг ашиглахгүй байх, төлбөртэй мэдээллийг ялгаж тэмдэглэхээс эхлээд бүх төрлийн авлигаас ангид байх, мэдээллийг шударга аргаар олж авах, сэтгүүлчийн мэдээлэл авах зорилго, арга хэлбэр ил тод байх мөрдлөгийг ёс зүйн зарчимд тусгасан байдаг.
2. Хэвлэл мэдээлэл засаглалын хувьд зөвхөн бодит байдлыг тогтоож мэдээлж байх нь ёс зүй дэх үнэт зүйл нь юм. Үүнд, сэтгүүлч сэтгүүл зүйн бүтээлдээ үзэл бодол шингээхээс татгалзах, түүнийг баримтаас ялгах, бүх төрөл, түвшний эх сурвалжтай ижил тэгш харилцаж тэдэнд байр сууриа илэрхийлэх боломжийг адилхан олгох гэх мэт зарчим багтана.
3. Нийгмийн харилцаа, тогтолцооны түвшинд хэвлэл мэдээлэлд байдаг үнэт зүйл нь бусдад болон сэтгүүлч өөртөө аливаа хор хохирол учруулахаас хамгаалж чадсан нөхцөл байдлаар илэрхийлэгдэнэ. Ямар ч мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиан болгож түгээхгүй байх, баримтыг мушгин гуйвуулах, хэн нэгнийг гүтгэхгүй, доромжлохгүй, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй байхыг ёс зүйн зарчмаар зохицуулж байна.
4. Ёс зүйн зарчмын агуулга дахь өөр нэг үнэт зүйл нь хүний эрхийн харилцаанд тулгуурлана. Хувийн нууц, уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандаж, хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг Хэвлэл мэдээллийн зөвлөл ёс зүйн зарчимдаа тусгасан байдаг.




Олон улсын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн суурь зарчмуудыг (10 зарчим) ЮНЕСКО-ийн Даян дэлхийн сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн суурь 10 зарчмыг үндэсний болон бүс нутгийн сэтгүүлчдийн ёс зүйн дүрэмд тусгах эх сурвалж болгон ашиглахаар боловсруулсан байна:



10 Зарчим

- Зарчим 1**
Иргэн хүн үнэн зөв мэдээлэл авах эрх
- Зарчим 2**
Үнэн, бодит байдлыг мэдээлэх нь сэтгүүлчийн үүрэг
- Зарчим 3**
Сэтгүүлчийн нийгмийн хариуцлага
- Зарчим 4**
Сэтгүүлчийн мэргэжилдээ үнэнч байх
- Зарчим 5**
Олон нийтийн хүртээмж ба оролцоо
- Зарчим 6**
Хувийн нууц, нэр төрийг хүндэтгэх
- Зарчим 7**
Олон нийтийн ашиг сонирхлын хүндэтгэх
- Зарчим 8**
Нийтийн үнэт зүйлс, соёлын олон янз байдлыг хүндэтгэх
- Зарчим 9**
Хүн төрөлхтөнд заналхийлж буй дайн болон өвчний эсрэг тэмцэх
- Зарчим 10**
Дэлхийн шинээр хөгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны зохицуулалт



Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” нь ерөнхий 10 заалт, 32 зүйлтэй.

10 Зарчим



Зарчим 1

Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.



Зарчим 2

Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.



Зарчим 3

Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.



Зарчим 4

Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.



Зарчим 5

Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.



Зарчим 6

Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.



Зарчим 7

Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.



Зарчим 8

Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.



Зарчим 9

Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.



Зарчим 10

Сонгууль: Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.

Дээр дурдсан Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл болон ЮНЕСКО-ийн ёс зүйн зарчмуудыг мэргэжлийн байгууллагууд бие даан боломжийн хэрээр дэмжин, сэтгүүлчиддээ түгээн дэлгэрүүлж ашиглах боломжтой.



Ёс зүйгээ зөрчвөл ямар хариуцлага хүлээх вэ?

Хэвлэл мэдээллийн салбарынхан жил бүр сэтгүүлчдийнхээ эрх ашгийг хамгаалах сэдвээр ярилцдаг ч нөгөө талд бодит мэдээлэл авах олон нийтийн эрх чөлөөний тухай тэр бүр дурддаггүй. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол ганц сэтгүүлчдийн “өмч” биш. Хичнээн шинэлэг, сонирхолтой, эрэн сурвалжилсан мэдлээлэл байгаад бодит байдлаас өөр бол олон нийтэд ямар ч үр өгөөжгүй. Тэгвэл үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэхэд ёс зүйн мөрдлөгө хамгийн их холбогдоно. Эндээс хэрвээ ёс зүйн зөрчлийн улмаас сэтгүүлч бүтээлээ бодит байдалд нийцүүлэн түгээж чадаагүй бол хамгийн түрүүнд олон нийтэд нэн хохиролтой гэдийг тэмдэглэе.

Харин ёс зүйн зөрчил гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, редакц ямар хариуцлага хүлээх вэ?

Юуны өмнө хэвлэл мэдээллээр нийтэлж, нэвтрүүлсэн бүтээл дэх ёс зүйн алдаатай холбоотой гомдлыг иргэнээс ирүүлсэн тохиолдолд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хорооны хурлаар авч хэлэлцээд мэргэжлийн дүгнэлт гаргадаг. Дүгнэлт нь сэтгүүлчийг дангаар нь шийтгэхээс илүүтэй хэвлэл мэдээллийн байгууллага, редакцид хамаатай байдаг. Хэрвээ Хэвлэл мэдээллийн байгууллага Ёс зүйн хороо хуралдахаас өмнө алдаагаа залруулсан эсвэл уучлал гуйсан тохиолдолд Ёс зүйн хороо шийдвэр гаргахдаа түүнийг нь харгалзан үзнэ.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хорооноос дараах шийтгэлийг хүлээлгэдэг байна.

- Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага гаргасан алдаагаа өөрөө залруулсан эсвэл уучлал гуйсныг мэдэгдэнэ.
- Тухайн хэвлэл мэдээллийн редакц ёс зүйн зарчим зөрчсөнийг мэдэгдээд шаардлагатай тохиолдолд Хорооны зөвлөмжийг зарлана.
- Зарим тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын нэрийг олон нийтэд зарлана.
- Тодорхой тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын нэрийг зарлахгүй.

Дээрх шийдвэрийн аль нь ч байсан Хорооны хуралдааны шийдвэрийг долоо хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон хариуцлага хүлээлгэсэн редакц өөрийн сувгаараа мэдээлдэг юм.



Редакцын хариу тайлбар өгөх эрх, ач холбогдол

Монгол улсын иргэн хэн боловч сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүйн алдаатай холбоотой гомдлоо Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлэх эрхтэй. Иргэний ирүүлсэн гомдлыг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажлын албанаас тухайн редакцад уламжилж холбогдох тайлбараа ирүүлэхийг хүсдэг юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц өөрийн сэтгүүлчийн бүтээлдээ тайлбар хийх эрх нь ийнхүү үүсдэг. Сэтгүүл зүйн мэдээ, сурвалжилга, нийтлэл, нэвтрүүлэг нь дан ганц сэтгүүлчийн бүтээл биш. Учир нь тухайн бүтээлд баримтын болон ёс зүйн хяналт шалгалт хийх сүүлийн дамжлага нь редакц өөрөө юм. Мөн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, сэтгүүл зүйн үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх, бүтээлийн сэдэв батлах, үүрэг даалгавар өгөх, төсөв мөнгө хуваарилах зэрэг эрх нь редакцад бий. Тиймээс ёс зүйн зөрчилтэй холбогдолтой гомдолд хариуцагч нь редакц байдаг. Хариу тайлбартаа редакц тухайн бүтээл хэрхэн бүтсэн, гомдолд дурдсан ёс зүйн зарчмуудтай холбоотой агуулга дээр ямар байр суурь баримталж байгаагаа юуны өмнө тайлбарладаг. Ингэж тайлбар хийхийн тулд редакц өргөн хүрээнд баримтаа дахин нягтлах, ёс зүйн зарчмаа лавшруулан судлах, харьцуулах, задлан шинжилгээ хийх зэргээр бүтээлчээр ажиллах шаардлагатай болдог. Энэ нь өөрөө ёс зүйд дахин дахин суралцах үйл явц юм. Нөгөө талаар сэтгүүлчид ч аливаа үйл явдлын талаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд редакцын хариу тайлбар нь тэрхүү эрх чөлөөгөө эдлэж буй хэлбэр гэж болно. Ингэж тайлбараа ирүүлсэн редакц дараагийн удаа үүнтэй ижил төстэй ёс зүйн алдаанаас сэргийлэх чадавхтай болж сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар нь улам хөгждөг байна.

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА САЛБАРЫН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ





ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА САЛБАРЫН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт яагаад чухал вэ?

Сэтгүүлч сэтгүүл зүйн ажлаа хийж байхдаа мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргах тохиолдол байдаг. Энэ нь сэтгүүлчийн ажил мэргэжлийн туршлага болон бусад гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалдаг. Тиймээс сэтгүүлчийг дахин алдаа гаргуулахгүйн тулд юу хийх хэрэгтэй, яавал зохистой болохыг зохицуулах зайлшгүй шаардлага хэвлэл мэдээллийн салбарынханд тулгардаг. Цагдаа, шүүхийнхэн сэтгүүлчийн алдаанд үндэслэн ихэвчлэн хорих ял оноох, мөнгөн торгууль ногдуулах зэргээр шийтгэдэг байна. Энэ нь сэтгүүлчийг айдаст автуулж, улмаар олон нийтийн төлөөх сэтгүүл зүйн ажлаа хараат бусаар гүйцэтгэх боломжгүй болох эрсдэлтэй юм. Улмаар ардчилсан нийгэмд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хумигдах, олон талт дуу хоолойг түгээх, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх боломж багасах, улмаар үгүй болох аюул бодитой бий болно. Иймд дэлхийн ардчилсан улс орнууд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог 100 гаруй жилийн өмнөөс бий болгож эхэлсэн.

Салбарын өөрийн зохицуулалт нь эгэх хариуцлагатай, ёс зүйт хэвлэл мэдээллийн хэм хэмжээг салбар нь өөртөө хүлээнэ гэсэн үг. Үүнийг улс төрөөс хараат бус, иргэний нийгмийн төлөөлөл болох Хэвлэл мэдээллийн зөвлөл хэрэгжүүлдэг. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хараат бус байдлын баталгаа нь түүний дүрэм, журам, бүтэц бүрэлдэхүүн, нөхөн сонголт, хорооны шийдвэр зэргээ өөрийн дүрмийн хүрээнд бие даан гаргадагт оршдог.

ЮНЕСКО-гоос 2011 онд баталсан “Илэрхийллийн эрх чөлөөг хамгаалахад Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын ач холбогдол” хэмээх бодлогын баримт бичиг боловсруулж, хэлэлцүүлсэн нь практикт ач холбогдолтой болж, жишиг стандартыг тогтоогоод байна. Уг баримт бичигт “Өөрийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийг хараат бус байдлаас сэргийлж, Засгийн газрын хатуу нөлөөллөөс хамгаалдаг. Хэвлэл мэдээлэл орчноо Засгийн газраас илүү ойлгодог учир зохицуулалтын тогтолцооны хувьд энэ нь үр өгөөжтэй байх боломжтой” хэмээн тайлбарласан.

Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд, сэтгүүлч, салбарын мэргэжилтэн, судлаач, олон нийтийн төлөөлөл болсон иргэдийн хүсэл, санаачилгаараа нэгдэн ёс зүйн зарчмаа хэлэлцэн баталж, түүнийгээ дагаж мөрдөх хэлцэлд



хүрснээр өөрийн зохицуулалт ажиллаж эхэлдэг. Ийм үзэл санааны үндсэн дээр Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл /ХМЗ/ 2015 онд байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. 2023 оны байдлаар ХМЗ нийт 555 гомдол иргэдээс хүлээн авч хэлэлцэж шийдвэрлэжээ.

Өөрийн зохицуулалтаар дамжуулан редакцын хараат бус байдлыг дэмжих



Хэвлэл мэдээлэл нь төр засаг болон олон нийтийн хооронд мэдээлэл солилцох гүүр болж байдаг. Энэ нь нэг талаас Төрийн мэдээллийг олон нийтэд хараат бусаар хүргэх, нөгөө талаас олон нийтийн үзэл бодлыг тэр хэвээр нь, бодитоор Төр засагт дамжуулах байдлаар илэрдэг. Иймээс хэвлэл мэдээлэл нь Төрөөс хараат бус оршин тогтнох ёстой. Монгол улсад хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг Үндсэн хууль болон Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажуулсан. Гэхдээ энэ нь хэвлэл мэдээлэл нийтэлж нэвтрүүлсэн агуулгынхаа төлөө хариуцлага огт хүлээхгүй гэсэн үг биш юм. Тэд мэргэжлийн алдаа гаргаснаас үүдсэн хариуцлагаа Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хүрээнд олон нийтийн өмнө хүлээдэг. Ийнхүү хариуцлага хүлээдэг ёс зүйн зарчмыг мөрдүүлэхийн тулд Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ажиллаж байна. Энэ зохицуулалтыг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд тусгасан байдаг. Энэ нь Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ, Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тогтоохгүй гэсэн заалт юм. Иргэн бүхэн сэтгүүлчдийн бүтээл дэх ёс зүйн алдаатай холбоотой гомдлоо Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлснээр хариуцлагатай, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй хэрэг юм.



Өнөөдөр Монгол Улсад хэвлэл мэдээллийн чөлөөт, хараат бус байдлыг хангах асуудал хангалтгүй хэвээр байгааг “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний индексээр манай улс 2021 онд дэлхийн 180 орноос 90 дүгээрт, 2022 онд 88 дугаарт эрэмбэлэгдэж, хэвлэлийн эрх чөлөөний талаар “мэдэгдэхүйц” асуудалтай орны тоонд багтаж байгаагаас харж болно. Шалтгааныг тайлбарлахдаа “Монголд гүтгэлэг, доромжлолтой холбоотой хэргүүдийн талаас илүү хувь нь сэтгүүлчид болон редакцын эсрэг нэхэмжилсэн нь тэднийг өөртөө цензур тавихад түлхэж байна. Ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн намууд болон улс төрчдөөс хамаарсан хэт төвлөрлийг үүсгэж буй нь бие даасан, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд саад болж байна” хэмээн тэмдэглэжээ.



Монгол Улсад 500 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж, дижитал орчинд эрчимтэй шилжиж, олон ургалч үзэл санаа оршин буй мэт боловч голлох нөлөө бүхий хэвлэл мэдээллийн байгууллагуудын 74.3 хувь нь улс төрөөс хамааралтай байгааг 2016 онд Хэвлэлийн Хүрээлэнгээс Хил хязгааргүй сэтгүүлчид олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн Хэвлэл мэдээллийг хэн эзэмшдэг вэ? судалгааны үр дүн харуулсан.



**MEDIA
OWNERSHIP
MONITOR
MONGOLIA**

ХЭВЛЭЛИЙН
ХҮРЭЭЛЭН

**REPORTERS
WITHOUT BORDERS**



Хэвлэл мэдээллийн хараат бус байдлын чухал хамгаалалтуудын нэг нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт (media self-regulation) юм. Баталгаатай, бодит байдалд нийцсэн мэдээлэл авах эрх иргэн бүрт бий. Энэхүү эрхийг хангахын тулд хэвлэл мэдээллийнхэн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээгээ тогтоож, хөгжүүлэх, улмаар иргэдийн оролцоотойгоор сахин мөрдүүлэх механизмыг Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд төдийгүй улс орнууд ардчиллыг бэхжүүлэхдээ бодлогын түвшинд анхаарч, практикт үр дүнтэй хэрэгжүүлэх явдал чухал болохыг олон улсын эрх зүйн зөвлөмжүүдэд тусгасан байдаг.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг улс орон бүр өөрийн улс төрийн соёл, эрх зүйн байдал, эдийн засаг, хэвлэл мэдээллийн хөгжил, төлөвлөөс хамааран янз бүрийн түвшинд хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байна.

Ардчилсан улс орнууд хараат бус, бие даасан хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага үүсгэх замаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хамгаалж байна. Харин ардчиллыг хөгжүүлж буй зарим улс оронд редакц болон иргэний хоорондын зөрчлийг шийдвэрлэх замыг сонгохдоо хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагыг албажуулж, хуулиар үүрэгжүүлж байгаа нь төрөөс хэвлэл мэдээллийн салбарт хяналтаа тогтоох оролдлого хэмээн ажиглагчид үзэж байна. Иймд ардчиллыг төлөвшүүлэхэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хараат бус байдал амин чухал бөгөөд түүнд нөлөөлөх үр өгөөж бүхий өөрийн зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх нь нэн чухал юм.



Аливаа улс оронд ардчилал, иргэний нийгэм бодитоор оршин буй эсэхийг танихын тулд олон нийтийн хэвлэл мэдээлэл нь хараат бусаар ажиллаж чаддаг уу, тэдгээрийн бие даасан байдлыг хэрхэн баталгаажуулдаг вэ гэсэн асуултад хариулах шаардлагатай болдог. Үүнд хариулахын тулд редакцын хараат бус байдалд улс төрийн нөлөөлөл хэр байдаг, бие даасан сэтгүүл зүйн хөгжлийг дэмжиж ажилладаг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо бүрэлдсэн эсэхийг харгалзан үздэг. “Олон нийтэд нөлөөлдөг хүмүүсийн тухай (улс төрч, албан тушаалтан, эрх мэдэлтнүүд гэх мэт) тухай мэдээлэл түгээхийг хязгаарлах, хорих болон нэр төр гутаахтай холбоотойгоор гүтгэлэг, доромжлолыг зохицуулах заалт бүхий эрүүгийн хуулийг хэвлэл мэдээллийг хянахад ашиглаж буй эсэх”-ийг харгалзан үзэх нь хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хэмжих нэг чухал шалгуур юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар “Хараат бус хэвлэл гэдэг нь Засгийн газар, улс төрийн болон эдийн Засгийн хяналтаас хараат бус, сонин хэвлэл гаргахад шаардлагатай үндсэн эд материалын болон дэд бүтцийн бэрхшээлээс хараат бус байх явдал” хэмээн үзжээ.

Хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд үр нөлөө бүхий өөрийн зохицуулалт чухал. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болоод мэдээллийн эрх чөлөөг хангасан эрх зүйн орчинд хөгжинө. Түүнчлэн өөрийн зохицуулалтын үндсэн зорилт нь хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлч, редакцыг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээгээ сахин мөрдөхөд нь дэмжиж хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байхад чиглүүлэх учиртай.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг гадаад болон дотоод хэмээн ангилж үздэг. Гадаад хүчин зүйлсэд улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн нөлөөллийг багтааж болох юм. Хэвлэл мэдээллийн байгууллага нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг улс төр, эдийн Засгийн хөндлөнгийн нөлөөллөөс ангид бие даан тодорхойлж, эрх зүйн хүрээнд түүнийгээ хэрэгжүүлдэг, салбарын өөрийн зохицуулалтын соёлыг улс төр, бодлогын түвшинд хүлээн зөвшөөрдөг байх нь гадаад хүчин зүйлээс хараат бус байх гол баталгаа болно.

Дотоод хүчин зүйлд эзэмшигч, эрхлэн гаргагч болон удирдлагын арга барил, редакцын дотоод харилцаа, бүтэц зохион байгуулалт, бодлого, дүрэм журам зэргийг хамруулж болох юм. Өөрөөр хэлбэл, гадны нөхцөл байдал ямар байхаас үл хамаарч тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн дотоод ардчиллыг хэрхэн бий болгож байгаагаар тодорхойлдог.



Технологи болон алгоритмын эрин үед сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэлд нийгмийн мэдээллийн сүлжээ (social network) болон нийгмийн мэдээллийн хэрэгсэл (social media) хамгийн том сорилт болж байна. Учир нь худал мэдээлэл, мушгин гуйвуулсан мэдээлэл, ялгаварлан гадуурхалт, үзэн ядсан үг хэллэг тархаж түгэхэд нийгмийн мэдээллийн хэрэгсэл хамгийн их нөлөө үзүүлдэг. Иймд улс орнууд худал мэдээлэл, үзэн ядсан үг хэллэгтэй тэмцэхдээ мэргэжлийн сэтгүүл зүйн үүрэг ролийг тодотгож, нийгмийн мэдээллийн хэрэгсэлд ч өөрийн зохицуулалт хийхийг шаардаж байхад, зарим улс оронд цахим орчин дахь хуулийн хатуу зохицуулалтыг илүүд үзэж байна.

Нийгмийн мэдээллийн сүлжээнд юуг, хэрхэн хэлэх нь жирийн иргэний хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол сэтгүүлчийн хувьд социал сүлжээнд ч мэргэжлийн ёс зүйн дүрмээ баримтлах учиртай хэмээн үзэх хандлага сүүлийн үед нэмэгдэх болов.

Сэтгүүлчид түгээж буй мэдээллээ нягтлан шалгаж, эх сурвалжаар баталгаажуулж, баримтжуулж, ямар ч баримт нотолгоогүйгээр хэн нэгний нэр хүндэд халдах, гутаан доромжлох үйлдэл хийхийг ёс зүйн кодоор хүлээн зөвшөөрдөггүй. Иймд сэтгүүлчдийн мэргэжлийн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлийг засаж залруулахын төлөө хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо ажилладаг.

Монгол Улсад гүтгэлэг, доромжлолтой холбоотой хэргүүдийн талаас илүү хувь нь сэтгүүлчид болон редакцийн эсрэг нэхэмжлэлтэй байгаа нь тэднийг өөртөө цензур тавихад түлхдэг. Төр хэвлэл мэдээллийг олон нийтийн хяналтад шилжүүлсэн үйл явц нь хэвлэл мэдээллийн орчинг ерөнхийд нь сайжруулсан. Гэвч ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн намууд болон улс төрчдөөс хамаарсан хэт төвлөрлийг үүсгэж буй нь бие даасан, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд саад болсоор байна.

Фрийдом Хаус Индекс (Freedom House Index)-ээр Монгол Улс улс төрийн эрх, эрх чөлөөгөөр 36 оноо, Иргэний эрх, эрх чөлөөний байдлаар 48 оноо авч нийтдээ 84 оноогоор чөлөөтэй орны тоонд багтсан байна.



Country	Total Score and Status	Political Rights	Civil Liberties
Mongolia	84 ■ Free	36	48
Montenegro	67 ■ Partly Free	26	41
Morocco	37 ■ Partly Free	13	24
Mozambique	45 ■ Partly Free	14	31
Myanmar	9 ■ Not Free	0	9
Nagorno-Karabakh*	37 ■ Partly Free	17	20

Монгол Улсад үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөний зөрчлүүд түгээмэл байгааг Глоб Интернэшнл төвийн жил бүрийн “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан”, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”, доктор О.Мөнхсайханы “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь” зэрэг судалгааны тайлангуудаас харж болно.

Глоб Интернэшл төвийн хэвлэлийн эрх чөлөөний тайлангуудад:

- Төрийн нууцын хүрээ хязгаарыг хэтэрхий өргөн тогтоодог;
- Хэвлэл мэдээллийн агуулгад хэтэрхий ерөнхий, тодорхойгүй хязгаарлалт тавьдаг;
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал ил тод биш;
- Цахим орчинд нэрээ нууцлах эрхийг хязгаарладаг;
- Мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгүүлэх, шүүлтүүр хэрэглэхийг шаарддаг;
- Сэтгүүлчийн эх сурвалжийн нууцлал хуулиар хамгаалагдаагүй;
- Гүтгэх, доромжлохыг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог, эдийн засгийн аргаар буюу торгуулиар дамжуулан цензур тогтоодог зэрэг бэрхшээлийг дурдсан байдаг.



Хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн тухай /дэлхийн улс орнуудад

Дэлхийн 100 гаруй улс оронд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх Хэвлэлийн зөвлөл (Press Council), Хэвлэл мэдээллийн зөвлөл (Media Council)-үүдийг үүсгэн байгуулсан боловч үйл ажиллагааны тогтвортой байдал харилцан адилгүй хөгжсөн байна.

Ерөнхийд нь ажиглавал, Баруун ба хойд Европын орнуудад хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын тогтолцоо үлгэр жишээ болохуйц байдлаар хөгжиж ирсэн байна. Анхны хэвлэлийн консул 1916 онд Шведэд байгуулагдсан бол 1960-аад оноос Баруун хойд Европ (Их Британид 1954, Германд 1956, Нидерландад 1960, Данид 1964, Финландад 1968, Швейцарт 1973 онд)-ын улс орнуудад ээлж дараалан байгуулагджээ.

Өдгөө эдгээр орнууд хамтран Европын хараат бус хэвлэлийн зөвлөлүүдийн нийгэмлэг (Alliance of Independent Press Councils in Europe) -ийг байгуулж хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын тогтолцоо, механизмыг бэхжүүлэхийн төлөө хамтран ажиллаж байна.

Энэхүү нэгдлийн гишүүн орнууд жилдээ нэг удаа хамтарсан бага хурлыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн гарц шийдлийг хайж гишүүн орнууддаа санал болгодог. Европын бүсийн бус орнуудад ажиглагч гишүүнээр нэгдэн эдгээр орнуудын туршлагаас суралцах боломж нээлттэй. Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл 2017 оноос тус нийгэмлэгийн ажиглагч гишүүнээр нэгдсэн.

PressCouncils.eu is the portal of the Media Councils in the Digital Age (MCDA) project supported by the European Commission to strengthen the European model of media self-regulation to protect media freedom and encourage professionalism in journalistic content

Ethical Codes Database

Codes of Ethics are a common tool that Media Councils use to communicate ethical principles to the general public, to educate journalists about ethics, and to make decisions in complaints procedures. Although the core journalistic values are the same across the European Union, their practical implementation varies from context to context. This module aims to make the Codes of Ethics from different regions in the European Union accessible, explorable, and comparable.

[ACCESS THE DATABASE](#)



1990-ээд онд Зөвлөлт Холбоот Улс задарснаар Зүүн Европ, Балканы хойгийн посткоммунист орнууд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хийж эхэлсэн бол Азид хожуу буюу 2000 оноос ижил зорилготой консулууд байгуулагдаж эхэлсэн. Азийн анхны хэвлэлийн зөвлөлд Энэтхэг, Шриланк, Тайланд, Пакистаны өөрийн зохицуулалтын байгууллагууд багтаж байгаа бөгөөд Монгол Улс 2015 онд хэвлэл мэдээллийн зөвлөлийг албан ёсоор байгуулсан түүхтэй. Зүүн Европ, Төв Ази, Зүүн өмнөд Азийн орнуудад хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын туршлага харьцангуй бага бөгөөд тухайн улсын улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран тогтвортой хөгжил нь саадтай хэвээр байна.

Харин Монголын ХМЗ-ийн сүүлийн арван жилийн туршлагыг загвар болгож суралцах, түгээн дэлгэрүүлэх талаар 2023 оны 7-р сард Бишкек хотноо болсон Төв Азийн хэвлэлийн мэдээллийн 24 дүгээр бага хурлын үеэр хэлэлцсэн юм. Энэ үеэр Төв Азийн хэвлэлийн зөвлөлүүдийн сүлжээ байгуулагдсан бөгөөд Монгол Улс гишүүнээр нэгдсэн билээ.

Ийм жишиг стандартыг ардчилал хөгжсөн улс орнуудаас эхлээд посткоммунист улс орнууд түгээмэл ашигладаг. Европын хараат бус хэвлэлийн зөвлөлүүдийн холбооны ихэнх гишүүн орнууд, мөн Босни-Герцогивини, Гүрж, Кыргызстан, Монгол зэрэг ардчиллыг хөгжүүлж буй улс орнуудын Хэвлэлийн зөвлөлүүд ийм загвараар хөгжиж байна. Эдгээр улс орнууд нь сайн дурын өөрийн зохицуулалтыг хараат бусаар хийхийг эрмэлзэж буй хэдий ч урт хугацааны тогтвортой хөгжилд нь олон саад бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, ардчиллыг хөгжүүлж буй улс орнуудын хэвлэл мэдээллийн зах зээлийн хөгжил сул байдгаас сэтгүүлч болон эздийн холбоод, редакцууд нь Хэвлэл мэдээллийн зөвлөлөө тогтвортой санхүүжилтээр хангаж чаддаггүй, салбарын бүх талуудын оролцоо, дэмжлэг хангалтгүйгээс хүлээн зөвшөөрөгдөж чаддаггүй гэх мэт эрсдэл ажиглагдаж байна.



Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хэлбэрүүд

Хамбургийн Их Сургуулийн профессор Ханс Ж.Клайнштойбер хэвлэл мэдээллийн салбарын хүрээн дэх зохицуулалтыг дараах байдлаар гурав ангилжээ. Үүнд:

- Бие даасан салбарын өөрийн зохицуулалт (self-regulation);
- Төрийн болон салбарын оролцоотой хамтын зохицуулалт (co-regulation);
- -Төрийн шууд зохицуулалт (state-regulation).

Сүүлийн үед өргөн нэвтрүүлэг, цахим ертөнцөд үүсэж буй ээдрээтэй асуудлуудыг зохицуулахад хамтын зохицуулалтыг хийж байна. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлогоос шалтгаалан хэвлэмэл болон цахим орчинд “өөрийн зохицуулалт” (self-regulation) голлодог бол өргөн нэвтрүүлгийн орчинд контент зохицуулалт, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалт зэргээс шалтгаалан “хамтарсан зохицуулалт” (co-regulation) хийх нь бий.

Өөрийн зохицуулалт нь ардчилсан нийгэмд хамгийн ээлтэй, бие даасан, хараат бус зохицуулалтыг салбарт нь үлдээдэг. Харин хамтарсан зохицуулалт нь Засгийн газар болон төрийн бус байгууллагын хамтын оролцоог санал болгодог.

Өөрийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэргэжлийн хэм хэмжээний тухай эргэцүүлэн бодох, түүнчлэн өөрийн зан үйлийн хэм хэмжээг боловсруулахыг шаардан мөрдүүлэх боломжтой.

Бие даасан салбарын өөрийн зохицуулалт: Сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтдаа хэлэлцэн салбартаа тохирсон, хүлээн зөвшөөрөгдсөн өөрийн зохицуулалтын байгууллагыг (Жишээ нь: Хэвлэл мэдээллийн зөвлөл) бий болгох замаар “сэтгүүл зүйн агуулгын чанар”-ын хариуцлагаа өөрсдөө хүлээнэ. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын зорилго, бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам, гишүүдийн оролцоог өөрсдөө тогтоохоос гадна хэвлэл мэдээллийн байгууллагууд нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, стандартуудыг баримталж ажиллах нь ямар нэгэн хөндлөнгийн, ялангуяа төр Засгийн оролцоогүйгээр өөрийн зохицуулалтаар явагдана.

Олон улсын сэтгүүлчдийн холбооны Эрх зүй, практикийн зарчимд “Хэвлэл мэдээллийн ёс зүй: ОУСХ ёс зүйг хуульчлахын эсрэг бөгөөд хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд өөрсдөө Засгийн газартай холбоогүйгээр



өөрийн зохицуулалтын бэхжсэн тогтолцоогоо хариуцан захирахыг дэмжинэ” гэжээ.

Үр ашигтай өөрийн зохицуулалтын тулгын гурван чулууг судлаач Х.Наранжаргал дараах байдлаар тодорхойлсон.

1. Улс төр, эдийн засаг, эздийн өрөөсгөл ашиг сонирхлоос ангид хараат бус байх;
2. Нийгэмдээ болон хэвлэл мэдээллийн салбартаа хүлээн зөвшөөрөгдөх;
3. Оролцооны болон санхүүжилтийн дэмжлэгтэй байх;

Төрийн оролцоотой хэвлэлийн зохицуулалт: Өөрийн зохицуулалтын системээс өөр хэлбэр буюу төрөөс хэвлэл мэдээллийн “чанарын” зохицуулалтыг хийхэд тодорхой хэмжээгээр оролцдог. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн “чанарын” зохицуулалтыг төрийн бус байгууллагаар дамжуулан хийлгэж буй эрх зүйгээр баталгаажсан хэлбэр юм. Энэ төрлийн хэд хэдэн хэлбэрүүд байдаг боловч тэдгээрийг дараах хоёр хэлбэрт ангилж үзэж болох юм.

1 дүгээр хэлбэр: Төрийн оролцоогүй (гэхдээ дэмжлэгтэй)

Хууль тогтоогч “Өөрийн зохицуулалт”-ыг хууль тогтоомж, түүнтэй адилтгах бичиг баримтад дурдаж өгнө. Ингэснээр төр өөрийн зохицуулалтын байгууллагын аливаа үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг. Мөн төр нь тухайн салбарт төрийн аливаа зохицуулалт хийхээс татгалздаг. Харин хуульд “Өөрийн зохицуулалт”-ыг дурдаж өгснөөрөө төрөөс хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг санхүүжилтийн хувьд дэмжих боломжтой болно. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтад төрийн ийм дэмжлэгийг авахыг дараах үндэслэлүүдээр зөвтгөдөг.

- 1) Төрөөс иргэнийхээ үнэнд нийцсэн, ёс зүйтэй мэдээ мэдээлэл хүлээн авах эрхийг хангаж, хамгаалахын тулд үүний төлөө ажиллаж буй институцийн тогтвортой хөгжлийг дэмждэг.
- 2) Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага ажилласнаар иргэн болон редакцийн хоорондын зөрчил маргааныг шүүх, хяналтын байгууллагаас өмнөх шатанд шийдвэрлэснээр шүүхийн ачааллыг эрс бууруулдаг.
- 3) Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрснөөрөө хэвлэлийн эрх чөлөөг дээдэлдэг ардчиллыг баталгаажуулсан улс орон гэдгээ харуулдаг.



Хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн хөгжлийн түүхээс харахад 1 дүгээр хэлбэрийн загвар нь тогтвортой хөгжлийг дэмжсэн үр өгөөжтэй загварт багтаж байна. Үүнд: ХБНГУ, Австри, Швейцари, Дани, Швед зэрэг ардчилсан улс орнуудын хэвлэлийн зөвлөл багтаж байна.

2 дугаар хэлбэр: Төрийн шууд оролцоотой

Энэ нь дараах хоёр хэлбэрээр ажиллаж байна.

- **Ахэлбэр:** Хууль тогтоогч нь Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга барилд /гишүүдийг сонгох, шийдвэр, шийтгэлийн хэлбэр, стандартыг тогтоох гэх мэт/ нарийвчилсан шаардлагуудыг тавьдаг. Ингэснээр хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанар, сонгодог хэлбэр алдагдаж, хуулийн албадсан хариуцлага болж хувирдаг. Энэ загварт жишээлбэл Балба, Мьянмарын хэвлэлийн зөвлөл багтдаг.
- **Б хэлбэр:** Хэвлэлийн өөрийн зохицуулалтыг шүүхийн, захиргааны шинж чанартай байдлаар шийдвэрлэдэг. Энэ тогтолцоонд ихэнхдээ төрийн төлөөлөлтэй байдаг ба зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, оролцоо байгаа боловч тэдгээрийн төлөөлөл, оролцоо, гишүүдийг сонгох журам, шийдвэр гаргах, хариуцлага тооцох механизм гэх мэт үйл ажиллагааг нь хуулиар тодорхойлдог. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон иргэд хооронд үүссэн маргааныг Арбитрын шүүхээр эвлэрүүлэн зуучлах байдлаар шүүхээс гадуур шийдвэрлэхээр үүрэгжүүлдэг, гомдол гаргагч шүүхэд хандахаас өмнө эхлээд заавал Арбитрын шүүхэд хандан, тэндээс шийдвэр гаргуулах хэрэгтэй болдог. Гэхдээ энэ нь өөрийн зохицуулалт гэхээсээ илүүтэй төрийн зохицуулалтын хэлбэрт багтдаг. Энэ загварт БНСУ, Индонез, Непал зэрэг Өмнөд Азийн голдуу хэвлэл мэдээллийн зөвлөлүүд багтаж байна.

Монгол Улс хэвлэл мэдээллийн ёс зүй ба өөрийн зохицуулалтын талаар баримталж буй бодлого

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг хамгаалахын тулд олон нийтийн хэвлэл мэдээлэл нь улс төрийн эрх мэдэл буюу Засгийн газрын хяналтаас хараат бусаар үйл ажиллагаагаа эрхлэх ёстой. Үүнийг хүлээн зөвшөөрөх нь улс орнуудын төр Засгийн үүрэг, хариуцлага юм. Эрх чөлөө, үүрэг хариуцлага



бол нэг зоосны хоёр тал. Хэвлэлийн эрх чөлөөг эдлэхтэй зэрэгцэж нийгмийн өмнө хүлээх хариуцлага олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд оногдоно. Үүнийг дагаад ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллахыг сэтгүүлч эрхэмлэхээс өөр аргагүй болдог. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хараат бусаар ажиллах эрх чөлөөг 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажуулсан бол үүрэг хариуцлагыг УИХ-ын дараах тогтоолуудад тодорхой тусгасан байдаг.

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.4.3-д нийгмийн тогтвортой байдлыг хангах хүрээнд “Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” гэж, мөн тус үзэл баримтлалын 3.6.1.4-д мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана” гэж тус тус заасан

Мөн УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батласан. Тус хөтөлбөрийн 8 дугаар зорилт нь иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр 4.1.8.3-д Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах тухай тусгасан.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах, мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх талаар тусгасан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төслийг хууль санаачлагч талууд боловсруулсан боловч УИХ-аар хэлэлцүүлж батлуулаагүй байна. Тухайлбал, 2014 онд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж санаачилж, УИХ-ын хэд хэдэн гишүүдийн өргөн барихаар бэлдсэн “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, мөн онд МУ-ын Засгийн газраас санаачлан боловсруулсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” тус тус боловсруулсан ч УИХ-ын хэлэлцүүлгийн шатнаас санаачлагч тал эргүүлэн татсан билээ. Хамгийн сүүлд 2018-2019 онд ХЗДХЯ-ны санаачилгаар “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/” төслийг боловсруулсан байна.



Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах эдгээр хуулийн төслүүд нь УИХ-аас 2010 онд баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2016 онд батласан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн үзэл санаанд тулгуурлан бичигдсэн байдаг. Хуулийн эдгээр төслүүдийн нийтлэг зүйл нь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хэвлэл мэдээллийн хариуцлагыг дээшлүүлэхэд голлон анхаарчээ. Ингэхдээ мэргэжлийн ёс зүйн хариуцлагыг төлөвшүүлэх үүрэг бүхий Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагыг эрх зүйн хувьд баталгаажуулахаар тусгасан нь анхаарал татдаг. Тухайлбал:

- 2011 онд МУ-ын Засгийн газраас боловсруулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай шинэчилсэн найруулгын төслийн 14.1-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус, өөрийгөө зохицуулах тогттолцоог бүрдүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй байна /цаашид Зөвлөл гэнэ/”;
- 2014 онд Ерөнхийлөгчөөс УИХ-д өргөн барьсан төсөлд “Хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлагыг мөрдүүлдэг өөрийн зохицуулалтын байгууллагатай байх бөгөөд түүний жилийн төсвийн 40 хувийг улсын төсвөөс санхүүжилнэ”;
- 2018 онд ХЗДХЯ-ны дэргэд байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга” төслийн үзэл баримтлалд “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа хараат бусаар тогтоох, мөрдүүлэх, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэж буй хэдий ч энэ байгууллагын чиг үүрэг, эрх зүйн байдлын талаар хуульд тусгагдаагүй тул батласан журам, шийдвэр нь заавал хүлээн зөвшөөрөгдөх шинжтэй бус, сайн дурын шинжтэй байна. Мөн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс эрх зүйн байдал, чиг үүргийг хуульд тусгаж, санхүүжилтийн тодорхой хувийг шийдвэрлэх хэрэгцээтэй”

хэмээн тус тус тодорхойлсон байдаг. Гэвч эдгээр төслүүд нь УИХ-аар хэлэлцүүлэгдээгүй юм.

Төрийн эрх барих дээд байгууллагуудаас хэвлэл мэдээллийн үүрэг, хариуцлагын тухай хөндөж, үүнийг эрх зүйн баримт бичгүүдэд тусгахыг хичээж байгаа нь нэг талаар олон нийтийн үнэнийг мэдэх эрхийг хангах төрийн чиг үүргээ биелүүлж буй мэт боловч нөгөө талаас хэвлэл мэдээллийн улс төрөөс хараат бус байх эрхийг хөндөх эрсдэл дагуулж буй юм. Иймд ардчилсан болоод ардчиллыг хөгжүүлж буй улс орнуудад хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангахын тулд ёс зүйн хариуцлагад төр



оролцдоггүй харин салбарын өөрийн зохицуулалтын механизмыг дэмжихэд гол бодлогоо чиглүүлдэг.

Дэлхийн 76 орныг нэгтгэсэн Нээлттэй Засгийн түншлэл хөтөлбөрт манай улс нэгдэж үзэл баримтлалд нь бодлогоо тусгаж тайлагнаад явж байгаа билээ. 2023 оны тайланд дурдсанаар бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /Шинэчилсэн найруулга/, Цахим гарын үсгийн тухай /Шинэчилсэн найруулга/, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулиуд 2021 оны 12 дугаар сард батлагдсан. Мөн Шүгэлдэгчийн эрх зүйн байдлын тухай, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн тус тус боловсруулан парламентаар хэлэлцүүлээр 2021-2023 оны үзэл баримтлалд тусгасан байдаг.

Түүнчлэн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/- т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлно. Авлигын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг зогсоож, аюулгүй байдлыг хамгаалах зохицуулалт бий болгоно. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ. Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ” хэмээн тусгаад байна.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр ашиг, давуу талууд

Хэвлэл мэдээллийг шууд төрийн зохицуулалтаар эсвэл ямар нэгэн хараат байдлаар зохицуулдаг нийгэмд иргэд нь хэвлэл мэдээллийг сонирхохоо больж, улмаар үл итгэх байдал нэмэгддэг. Энэ нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилж, улмаар олон нийтийн мэтгэлцээнийг үгүйсгэдэг. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь тухайн улс орны хэвлэл мэдээллийн итгэл үнэмшлийн баталгаа болж, сэтгүүл зүйн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлснээр борлуулалтын болон зар сурталчилгааны орлогыг өсгөдөг.

Өөрийн зохицуулалт нь **хэвлэл мэдээллийн эрх чөлөөг** дэмждэг. Учир нь хууль эсвэл тодорхой дүрэм журмаар зохицуулж буй үед ямар нэг хэмжээгээр хязгаарлалтыг хэтрүүлэх, урвуулан ашиглах тохиолдол



гардаг. Түүнчлэн хэвлэл мэдээлэл, хувь сэтгүүлчид, цахим мэдээллийн хэрэгслүүдэд торгууль ногдуулах, бизнест хохирол учруулах зэрэг сөрөг үр дагавар ч гардаг. Энэ нь ардчиллын үнэт зүйлийн нэг болсон чөлөөт хэвлэл мэдээллийг гажуудуулж, хэвлэл мэдээллийн бизнест сөргөөр нөлөөлдөг. Харин хуулийг даган мөрдөхийн зэрэгцээ өөрийн зохицуулалтын механизмыг хэрэгжүүлэх нь хэвлэл мэдээлэлд дээрх хохирлоос зайлсхийхэд тусалдаг төдийгүй мэргэжлийн алдаа гаргахаас сэргийлэх, хэрэв алдаа гаргасан бол түүнийгээ ойлгож залруулах боломжийг олгодог. Энэ утгаараа мэргэжлийн өндөр түвшинд чанартай үйлчилгээ үзүүлэх, хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хэвлэлийн эрх чөлөөг дэмждэг.

Өөрийн зохицуулалтын үйл ажиллагаа нь ялангуяа **энгийн иргэдэд хүртээмжтэй бөгөөд өгөөжтэй** байдаг. Хэвлэл мэдээллээр нягталж шалгаагүй алдаатай эсвэл доромж, нэр төрд нь халдсан мэдээлэл цацагдсан тохиолдолд үүнийг засаж залруулах боломжийг иргэдэд олгодог. Өөрийн зохицуулалт нь шүүх, хууль хяналтын байгууллагад хандахаас хамаагүй хялбар бөгөөд зардал гаргахгүйгээр гомдлоо гаргаж болдогоороо энгийн иргэдэд ойр байдаг. Хэн ч хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол гаргахдаа ямар нэгэн төлбөр төлөхгүй, шүүх, хууль хяналтын байгууллагатай харьцуулахад цаг хугацааны болон эдийн Засгийн алдагдалгүйгээр шийдвэрлүүлж чаддаг. Түүнчлэн иргэд гомдол гаргах үйл явцтай энгийн бөгөөд ойлгомжтой байдлаар танилцах боломжтой. Хэн нэгэн ХМЗ-д гомдол ирүүлэнгүүт үүнийг нь гомдол хаяглагдсан тухайн хэвлэл мэдээллийн байгууллага руу илгээж, тэдний байр суурийг асуудаг. Ингэснээр хэвлэлийн зөвлөл баримтыг нягталж, асуудлыг зөв байранд нь тавих харилцааны үүргийг хүлээдэг юм.

Өөрийн зохицуулалтын ажлын арга барил нь **уян хатан** байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллага алдаагаа тогтоож, засаж залруулах, асуудлыг олон талаас харах боломжийг олгож, хэтрүүлсэн бол уучлал гуйх, буцаан хариу өгөх боломжоор хангасан нийтлэл гаргах зэргээр асуудлыг шийдэх олон янзын аргыг ашигладаг.

Өөрийн зохицуулалт нь **шуурхай**. ХМЗ-ийн шийдвэрийн үйл явц нь гомдлыг аль болох хурдан хэлэлцэж, үр дүнг танилцуулахад чиглэдэг. ХМЗ нь асуудлыг албан бус байдлаар авч үзэхгүйн тулд гомдлын талаарх мэдээллийг аль болох хурдан хугацаанд талуудад мэдэгддэг.

Эцэст нь өөрийн зохицуулалтын хамгийн чухал үр ашиг нь хэвлэл мэдээллийн салбарын олонхоор хэлэлцэн батласан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хүрээнд асуудлыг авч үзсэнээр хэвлэл мэдээллийг илүү мэргэжлийн өндөр түвшинд ажиллуулж, үнэн бодит мэдээ, мэдээллээр иргэдийг хангах, **хүний эрх, эрх чөлөөг** хамгаалдаг.



Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь нэгдүгээрт; хэвлэл мэдээллийг мэргэжлийн хэм хэмжээгээ баримтлан ажиллаж, иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэхэд тусалдаг, хоёрдугаарт; хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтийн эрх ашгийг хөндсөн өргөн хүрээний асуудлыг нийтэлж, нэвтрүүлэхдээ ямар хэм хэмжээг баримталдаг талаар олон нийтийн ойлголтыг тодорхой болгодог. Үүнээс гадна сэтгүүлчид ёс зүйн зарчмыг амьдралд хэрэгжих боломжгүй гэж үзвэл засаж өөрчлөх санал дэвшүүлэх боломжтой байдаг.

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЛЭСЭН
ГОМДЛУУДАД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ**



Хавсралт

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЛЭСЭН ГОМДЛУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.Нарантуяа, ХМЗ-ийн хараат бус зөвлөх


ХМЗ-д ирүүлж буй гомдлын агуулгад дүн шинжилгээ хийснээр редакц, сэтгүүлчдийн мэргэжлийн түвшинг илэрхийлэх, хэрэглэгчид сэтгүүл зүйн бүтээлийг хэрхэн үнэлж байгааг тодорхойлох, ХМЗ-ийн Ёс зүйн хороод гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаад дүн шинжилгээ хийх боломжтой юм.

ӨМНӨТГӨЛ

Монголын сэтгүүлчдийн өргөн зөвшилцлийн дүнд 2015 онд байгуулагдсан Хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, мэргэжлийн стандартыг мөрдүүлэх зорилготой. Дэлхийн улс орнууд сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг сахин мөрдүүлэх зорилгоор ийм чиг үүрэг бүхий байгууллагыг ажиллуулдаг туршлагатай. Ийм байгууллагыг сайн дурын үндсэн дээр эсвэл хууль эрх зүйгээр байгуулж, Хэвлэлийн зөвлөл, Хэвлэлийн консул, Ёс зүйн хороо гэх зэргээр нэрлэж байна. Хэдийгээр ийн өөр өөрөөр нэрлэж байгаа ч ерөнхийд нь өөрийн зохицуулалтын байгууллага хэмээн томъёолно. Сайн дурын үндсэн дээр болон хуулиар байгуулагдсан аль нь ч бай гүйцэтгэх үүрэг, механизмын хувьд төстэй. Сэтгүүлчийн бэлтгэсэн бүтээлд /мэдээ, сурвалжилга, нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлага гэх мэт/ мэргэжлийн ёс зүй зөрчигдсөн гэж үзсэн гомдлыг олон нийтээс хүлээн авч, мэргэжлийн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар уг бүтээлд ёс зүйн дүгнэлт гаргадаг. Гаргасан дүгнэлт нь өөрийн зохицуулалтын байгууллагыг хэрхэн байгуулснаас хамаарч зөвлөмж хэлбэртэй, эсвэл шүүхийн шийдвэртэй дүйцэхүйц заавал биелүүлэх журамтай байна.

Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хувьд дүгнэлтийг зөвлөмж байдлаар гаргаж ёс зүйн зөрчил гаргасан редакцуудад мэдэгдэх хэлбэрээр ажиллаж ирлээ.

Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны дөрөвдүгээр сараас гомдол хүлээн авч шийдвэрлэж байна. Гомдол хүлээн авч эхэлснээс хойш 2021 оныг дуустал хугацаанд 457 гомдол хүлээн авч шийдвэрлэжээ.



Гомдол хүлээн авч эхэлснээс хойш гомдлын тоо тасралтгүй өсч ирсэн боловч 2020-2021 онд буурсан нь Ковид-19-ийн цар цахлын дэглэмтэй холбон үзэж болно.

ХМЗ-д ирж буй гомдлуудыг болон ирсэн гомдлуудын агуулга болон Ёс зүйн хороод хэлэлцэн гаргасан дүгнэлт нь Монголын сэтгүүл зүйн ерөнхий өнгө төрх, редакц болоод сэтгүүлчдийн мэргэжлийн түвшинг илтгэх нэг индикатор болж байна. Ирж буй гомдлуудад дүн шинжилгээ хийснээр хэвлэл мэдээллийн салбарын цаашдын хөгжлийн зөв чигийг гаргах ач холбогдолтой.

Монголын сэтгүүлчдийн одоо даган мөрдөж буй Ёс зүйн зарчим нь 10 заалт, 32 зүйлтэй. Эдгээр 10 заалтаас хамгийн их гомдол орж ирдэг заалтууд нь НЭГДҮГЭЭР буюу **“Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно”** гэсэн заалт юм. Үүнийгээ цааш нь нарийвчлах юм бол **1.1** буюу “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”, **1.2** буюу “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ”, **1.6** буюу “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана” гэсэн зүйлүүд байгаа нь сэтгүүлчид, редакцууд мэдээллээ бататгах, нягтлах, эх сурвалжтай мэдээлэл бэлтгэх үндсэн гол үүргээ хангалттай биелүүлэхгүй байна гэж дүгнэж болохоор байна.



Нэгдүгээр заалтаас гадна олон удаа зөрчигдөж байгаа заалтууд нь **ГУРАВДУГААР** буюу “Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй”, **ДӨРӨВДҮГЭЭР** буюу “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана”, **ЗУРГАДУГААР** буюу “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана” гэсэн заалтууд байна.

Гомдол их ирж байгаа заалтуудаар сэтгүүлч, редакцын мэдлэг, чадварыг дээшлүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

НЯГТЛАН ШАЛГАХ ЭНГИЙН ДҮРМЭЭ БАРИМТАЛ

Эх сурвалжтай байх, баримтаа нягтлах нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны заавал дагаж мөрдөх энгийн дүрэм. Ёс зүйн зөрчилтэй гэсэн дүгнэлт гарч байгаа гомдлуудын дийлэнх нь энэхүү энгийн дүрмийг мөрдөөгүйгээс үүдэлтэй байна. Сэтгүүлч бичиж байгаа мэдээллээ худал биш бодит гэдгийг баримтаар нотолж, эх сурвалжаар баталгаажуулаагүй л бол энэ нь сэтгүүл зүйн ажил биш юм. Ялангуяа олон нийтийн сүлжээний олон сувгаар хүмүүс хангалттай мэдээлэл авч, бас бусадтай хуваалцах, мэдээллээ чөлөөтэй цацах боломжтой цаг үед бид амьдарч байна. Нэгэнт мэдээлэл хуваалцах, түгээх чөлөөт талбар байгаа ч тэдгээрийг зөвхөн сайн сайхны төлөө ашиглаж байгааг хэн ч баталж чадахгүй. Энэ нь худал мэдээлэлтэй тэмцэх ёстой гэсэн хандлага, үзэгдлийг дэлхий нийтэд бий болгосон. Өнөөдөр сэтгүүл зүйн холбогдолтой бүхий л том, жижиг хэлэлцүүлгийн хэлэлцэх асуудалд худал мэдээлэлтэй хэрхэн тэмцэх, худал мэдээллийг хэрхэн таних сэдэв заавал байх болжээ. Олон нийтийн сүлжээгээр хэн хүссэн нь мэдээллээ хуваалцдаг болж, сэтгүүлчид ер нь байх хэрэгтэй юу гэж хэлэлцэх болсон энэ цаг үед баримт нотолгоотой, эх сурвалжтай мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ түгээх нь мэргэжлээ, салбарынхаа нэр хүндийг хамгаалж үлдэх гарц юм.

БАРИМТ

2020 оны арваннэгдүгээр сарын 25-ны өдөр нэр бүхий хоёр сайтад “Хонины мах 16000 төгрөгөөр зарсан Good Price дэлгүүрийг 20 сая төгрөгөөр торгожээ” гэсэн мэдээ нийтлэгдсэн. Гэтэл энэ нь ташаа мэдээлэл гэсэн гомдлыг уг дэлгүүрийн толгой компани “Үлэмж Гросерс” ХХК гаргаж ХМЗ-д ирүүлсэн юм. Гомдлын мөрөөр нягтлахад сэтгүүлч баримтаа шалгаагүй, хайнга хандсан алдаа гаргасан байв. Мэдээндээ үхрийн махыг 16000 төгрөгөөр зарсан гэж зөв бичсэн боловч гарчганд хонины мах гэж андуурч бичсэн.



БАРИМТ

2021 оны гуравдугаар сарын 20-нд нэгэн сайтад “Цэцэд санаархсан “хараат” нэр дэвшигчид хэн нь хэн бэ” гэсэн гарчигтай мэдээ гарсан бөгөөд Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд нэр дэвших магадлалтай хүмүүсийн талаар дурдсан. Эдгээр нэр дэвшигчдийн нэрс дунд В.Удвал гэсэн хуульч байсан бөгөөд хүү нь бас хуульч хүүтэй, хуулийн салбарт гэр бүлээрээ байдаг гэсэн боловч нэр дурдагдсан Б.Удвал биш мөн Н.Удвал нэртэй өөр хуульчтай андуурсан.

БАРИМТ

2018 оны тавдугаар сарын 29-ний өдөр нэгэн сайтад “Хатан Туулыг ширгээгч С.Амарсайханыг даваргасаар байх уу” гарчигтай нийтлэл гарсан. Энэхүү нийтлэлд тухайн үед Улаанбаатар хотын Захирагчаар ажиллаж байсан С.Амарсайхан нь Зайсан орчмын газрыг хууль бусаар авсан тухай бичсэн боловч хууль бусаар авсан гэдгийг нотлох эх сурвалжгүй, нийтлэлд дурдагдсан эх сурвалжуудыг бусад хэвлэлээс эшилсэн, “ерөөсөө хууль дүрэм бидэнд хамаагүй гэдэг хандлага цусанд нь шингэсэн гэр бүл аж” гэсэн доромж үгтэй.

БАРИМТ

Нэгэн сэтгүүлд хэвлэгдсэн “Эрүүл мэндийн даатгалын эрүүл бус тогтолцоо” нийтлэлд ЭМДЕГ гомдол ирүүлсэн. Уг нийтлэлд ЭМД-аар 12 үйлчилгээ үзүүлдэг байхад 8 гэж, дээд тал нь 2 сая төгрөг хүртэл үйлчилгээ үзүүлдэг байтал 30.000 гэж ташаарсан байсан.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ЭХ СУРВАЛЖ МӨН ҮҮ?

Эх сурвалж гэж юуг ойлгох вэ гэдгийг сэтгүүл зүйн сурах бичигт тодорхой бичсэн байдаг. Сэтгүүлчийн олон нийтийн тусын төлөө мэдээ мэдээлэл бэлтгэхдээ сурвалжилж буй үйл явдал, сэдвийн бодитой, тэнцвэртэй байдлыг хангахын тулд эх сурвалжийг ашигладаг. Эх сурвалж гэдэг бол уг мэдээлэлд хамаатай хүнээс гадна албан ёсны тоо баримт, албан бичиг, тайлан, гүйцэтгэл, хэвлэлийн бага хурал бүгд эх сурвалж мөн. Сошиал сүлжээнд тавигдсан мэдээлэл ч эх сурвалж мөн. Гэвч эх сурвалжийн хэлсэн зүйл бодит байдалд нийцэж байгаа юу гэдгийг нягтлах нь сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг.



ХМЗ-д ирсэн гомдлуудад хэвлэлийн бага хурлын мэдээллийг дамжуулсан редакцуудад холбогдох гомдол харьцангуй олон ирж байгаа нь анхаарал татаж байна. Энд нэг сонирхолтой жишээ татъя.

Харвардын Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны салбар нэгж болох “Монголын эрүүл мэндийн үүсгэл” НҮТББ 2018 онд ХМЗ-д хандан гомдол гаргасан. Уг гомдол телевиз, сонин, сайт гээд хэд хэдэн редакцын бэлтгэсэн мэдээлэлд хамаарч байсан бөгөөд эдгээр редакц 2018 оны дөрөвдүгээр сарын 24-ний өдөр Монголын эцэг, эхийн үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан хэвлэлийн бага хурлын мэдээллийг өөр өөрсдийн форматаар бэлтгэн түгээсэн байсан. Хэвлэлийн бага хурал хийсэн хүмүүс сургуулийн насны хүүхдүүдийг вакцины туршилтад хууль бусаар хамруулсан гэсэн мэдээллийг өгсөн юм. “Монголын эрүүл мэндийн үүсгэл” НҮТББ нь “Сургуулийн насны хүүхдүүдийн сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэхэд Д аминдэмийн нөлөө” судалгааны хүрээнд хүүхдүүдэд уг вакциныг хийсэн юм. Монголын эцэг эхийн үндэсний зөвлөлийнхөн энэхүү судалгааны талаар хэвлэлийн бага хурлын үеэр ташаа мэдээлэл өгсөн гэж үзэж байсан бөгөөд уг мэдээллийг түгээсэн редакцууд нь хэвлэлийн бага хурал хийсэн иргэдийн байр суурийг мэдээлэхдээ бусад эх сурвалжаар баталгаажуулаагүй, буруутгаж буй судалгааны байгууллагаас нягтлан тодруулаагүй, тэдэнд тайлбар өгөх боломж олгоогүй гэж үзэн Ёс зүйн зарчмын **1.1, 1.2, 1.6, 1.8, 1.9-р** заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаагаа гомдолдоо тусгасан.

Телевизийн редакцад хамааралтай гомдлыг Радио, телевизийн Ёс зүйн хороо, сонин, сайтын редакцад хамааралтай гомдлыг Сонин, сайт, сэтгүүлийн Ёс зүйн хороо хэлэлцсэн. Сонирхолтой нь Радио, телевизийн Ёс зүйн хороо “Монголын эрүүл мэндийн үүсгэл” байгууллагын гомдол үндэслэлтэй, нэр дурдагдсан телевизийн редакцуудын нэгээс бусад нь ёс зүйн алдаа гаргасан, ингэхдээ **1.1** болон **1.8-р** заалтыг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан. **1.1** гэдэг бол *“Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”*, **1.8** бол *“Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно”* гэсэн заалт юм. Харин NTV телевизийн мэдээллийг ёс зүйн зөрчилгүй гэж дүгнэсэн бөгөөд тус редакц нь хэвлэлийн бага хурал хийсэн иргэдийн мэдээллийг олон талын эх сурвалжаар баталгаажуулсан, эх сурвалжаа тодорхой дурдсан, мэдээллийг гуйвуулаагүй, үзэл бодол оруулаагүй байсан учраас ийн дүгнэсэн юм.

Харин Сонин, сайт, сэтгүүлийн Ёс зүйн хороо нэр дурдагдсан редакцын мэдээлэл нь “Нээлттэй эх сурвалжтай, үзэл бодлоо илэрхийлсэн хэвлэлийн бага хурлын мэдээллийг тоймлон дамжуулсан, ямар нэгэн сэтгүүлчийн



таамаг, үзэл бодол оруулаагүй” гэж үзэн редакцууд ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзсэн юм.

Хэвлэлийн бага хурлыг нээлттэй эх сурвалж гэж үзэж болох ч нэг талын, эрх ашиг бүхий эх сурвалж гэдгийг байнга санах учиртай. Хэвлэлийн бага хурлын мэдээллийг тоймлож дамжуулах нь сэтгүүл зүй биш гэдгийг мэргэжлийн редакцууд анхаарч, хэвлэлийн бага хурал хийсэн талын мэдээллийг бусад эх сурвалжаар баталгаажуулж, бодитой тэнцвэртэй мэдээлэл өгдөг болох нь зүйтэй юм.

Хэвлэлийнхэнд зориулан гаргадаг албан ёсны Хэвлэлийн мэдээ /Press release/ мөн нээлттэй эх сурвалжид хамаарах тул хэвлэлийн мэдээг боловсруулалт хийлгүйгээр шууд эх хувиар нь түгээх нь зөвхөн нэг талын байр суурь гэдгийг ямагт санах нь зүйтэй. Хэвлэлийн мэдээг үнэн гэж итгэх нь ёс зүйн зөрчил гарах хангалттай нөхцөл юм. Хэвлэлийн мэдээг шууд түгээснийг ёс зүйн зөрчил гэж үзсэн гомдол нэг биш удаа ХМЗ-д ирж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

РЕДАКЦУУДЫН ЯЛГАРАЛ

Өмнөх жишээнд өгүүлсэн NTV телевизийн тохиолдол бол редакцын мэргэжлийн байх тэмүүлэл, төлөвшил, соёл чухал гэдгийг харуулж байна. Гомдолд 10 илүү редакцын нэр дурдагдаж, тэд бүгд хэвлэлийн бага хурлын мэдээллийг байгаагаар нь дамжуулсан байхад NTV үзэгчдэдээ тэнцвэртэй, бодитой мэдээлэл өгөх зарчмаа барьж ажилласан. Коронавирусийн хөл хорио бүрэн тавигдаагүй байх үед нэгэн аймгийн эмч төрийн шагнал авсныг байгууллагаараа тэмдэглээд бараг бүх ажилтан нь халдвар авсан тухай хэд хэдэн редакц мэдээлсэн. Нэр дурдагдсан эмнэлгийн зүгээс ташаа мэдээлэл түгээлээ гэсэн гомдлыг ирүүлсэн бөгөөд гомдлыг шалгаж үзэхэд энэ тухай мэдээлсэн редакцуудаас ганцхан NTV эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хадгалсан байсан юм. Ийнхүү NTV телевизийн редакц хоёр ч удаа мэргэжлийн ёс зүйгээ баримталж чадсан учраас ийнхүү онцгойлон дурдаж байна.

ХМЗ-д ирүүлсэн гомдолд нэр дурдагдсан редакцуудад “танай бэлтгэн түгээсэн ийм мэдээнд гомдол ирлээ, Ёс зүйн зарчмын эдгээр зарчмыг зөрчсөн гэж гомдогч үзсэн байна, та бүхэн тайлбараа ирүүлнэ үү” гэсэн утгатай албан бичгийг илгээдэг. Редакц үүнд тайлбар ирүүлэх нь маш ач холбогдолтой. Редакц тухайн мэдээллийг мэргэжлийн хүрээнд бэлтгэсэн ч санамсаргүй алдаа гаргасан бол, эх сурвалжаа хамгаалах үүднээс нууцалсан бол, мэргэжлийн ёс зүйгээ зөрчсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн бол



хариу тайлбартаа дурдаж нээлттэй ажиллах нь зөв бөгөөд ингэж ажиллаж чадаж байгаа эсэхээс тухайн редакцын мэргэжлийн байх, төлөвшилтэй байх нь харагддаг. Мэдээж редакцын тайлбар ёс зүйгээ зөрчсөнийг зөвтгөхгүй ч алдаагаа ухамсарласан редакцын нэрийг олон нийтэд дурдахгүйгээр хурлын шийдвэрээ олонд танилцуулдаг хүнлэг журам ХМЗ-д үйлчилдэг.

Мэргэжлийн төлөвшсөн редакц гэдгээ үргэлж харуулдаг хэвлэл мэдээллийн байгууллага олон байгаа нь талархуштай.

ЭРЭН СУРВАЛЖЛАГЫН ГОЛ ДҮРҮҮД ГОМДОМТГОЙ

ХМЗ-д ирж буй гомдлын багагүй хувийг сэтгүүлчдийн эрэн сурвалжилсан нийтлэл, нэвтрүүлгүүд эзэлж байна. Эрэн сурвалжилга бол сэтгүүлчийн уйгагүй хөдөлмөр, няцашгүй оролдлогын үр дүнд цаг хугацаа зарцуулан бий болдог бүтээл. Эрэн сурвалжилсан бүтээлд олны нүдэнд тэр болгон ил харагдаад байдаггүй буруу үйлдлийг баримтаар нотолдог. Илчлэгдсэн баримтад нэр холбогдсон хувь хүн, байгууллага “сэтгүүлч намайг, биднийг гүтгэсэн, нэр хүндийг гутаасан” гэж үзэн гомдол гаргах нь түгээмэл байна. Эрэн сурвалжилсан бүтээл нь баримт, нотолгоотой байдаг ч санамсаргүй алдаанаас болж редакц буруудах тохиолдол бий.

БАРИМТ

2020 оны нэгдүгээр сарын 25-ны өдөр нэгэн телевизээр “Монголын хөл бөмбөгийн холбоон дахь бэлгийн хүчирхийлэл-2” нэвтрүүлэг цацагдсан. Энэ бол маш сайн эрэн сурвалжилсан нэвтрүүлэг. Редакцын зүгээс ирүүлсэн тайлбартаа үүнийгээ дурдсан байсан. Уг тайлбарт сэтгүүлч энэ нэвтрүүлгийг бэлдэхийн тулд гурван сарын турш баримт цуглуулсан, эмзэг сэдвийн тухай хөндөж байгаа учраас хохирогчдыг хамгаалах үүднээс дуу хоолойг өөрчлөх, царайг танигдахгүй болгох, зарим үйлдлийг жүжигчлэн зохиомжилсон гэдгээ дурдсан. Гэвч харамсалтай нь нэвтрүүлгийн дундуур хохирогчдын бөөндөө авахуулсан зургийг танигдахуйц байдлаар харуулсан нь алдаа болж, Ёс зүйн зарчмын **2.3** буюу “Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна” гэсэн заалтыг зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан.



БУСДЫН ЭРХ АШГИЙН МАРГААНД ТАТАГДАН ОРОХООС СЭРГИЙЛЭХ


Улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд гарч байгаа эрх ашгийн зөрчилдөөнд сэтгүүлчид татагдан орох тохиолдол байна. Албан тушаалын эрх ашиг, бизнес хоорондын маргаан, улс төрийн намууд эрх мэдлийн төлөөх эрх ашгийн тэмцлээ хэвлэлээр дамжуулан илэрхийлж байгаа бөгөөд ийм төрлийн мэдээлэл нь хэдийгээр эх сурвалжтай, эзэн биетэй мэт боловч нэг талын тэнцвэргүй мэдээлэл юм.

БАРИМТ

2020 оны есдүгээр сарын 5-ны өдөр Хөдөлмөрийн Үндэсний нам /ХҮН/-ын нийслэлийн хорооны хурлыг мэдээлсэн хоёр редакцад хаяглан ХҮН-аас гомдол ирүүлсэн. Намаас ирүүлсэн гомдолд “редакц мэдээллийг бэлтгэхдээ намд 2018 он хүртэл гишүүн байсан, одоо гишүүнчлэлгүй, холбоо хамааралгүй бүлэг этгээдүүд намын нэр, таних тэмдгийг зөвшөөрөлгүйгээр ашиглан улс төрийн үзэл бодлоо илэрхийлснийг нягтлалгүй олон нийтэд нэг талын баримт, эх сурвалжтай ор үндэсгүй, буруу ташаа, хуурамч мэдээ дамжуулсан” гэж үзсэн. Хороо хэлэлцээд зөрчил гаргаагүй гэж үзсэн. Гэхдээ хэдийгээр тухайн редакцын мэдээ мэргэжлийн хэм хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн учраас зөрчил гаргаагүй гэж үзсэн ч энэ үйл явдал нь тус намын дотоод зөрчлөөс үүдэн хэсэг нөхөд нь тусдаа хурал зарласан байсан. Үйл явдлын өрнөлөөс нэг хэсгийг салган авч мэдээлэхгүй байх нь, учир шалтгааныг дурдах нь сэтгүүлч, редакцын үүрэг байх учиртай.

БАРИМТ

Одоо Шадар сайдаар ажиллаж буй С.Амарсайханыг Улаанбаатар хотын Захирагчаар томилогдохын өмнө болон томилогдсоны дараа түүний эсрэг мэдээллийн зохион байгуулалттай дайралтууд хэвлэлээр хийгдэж, ХМЗ-д ч нэг биш удаа гомдол ирж байсан. Тухайлбал, “Зайсангийн зүүн сугыг гижигдэх нь гэмт хэрэг мөн”, “Хотыг холгогч С.Амарсайханы шуналын золиосонд Зайсан толгой, Хатан Туул өртсөөр”, “Хатан Туулыг ширгээгч С.Амарсайханыг даваргасаар байх уу” гэсэн гарчигтай нийтлэлүүдэд сэтгүүлч ёс зүйн алдаа гаргасан гэсэн гомдол ирж байсан. Албан тушаалын томилгоо тойрсон тэмцлийн нэгээхэн хэсэг хэвлэлээр, сэтгүүлчдээр дамжин хийгдэж байгаа нь ийнхүү ХМЗ-д гомдол болон ирдэг.



БАРИМТ

Компани хоорондын маргаан, эрх ашиг бүхий бүлгүүдийн хоорондын зөрчилдөөнийг нэг талын эрх ашгийг барин олон хэвлэл зэрэг мэдээлэх арга барил сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйд үзэгдэх болсон нь мөн л гомдол болон ХМЗ-д ирсэн жишээ нэг биш. Үүний нэг нь 2019 оны тавдугаар сарын 22-ны өдөр хэд хэдэн телевизийн мэдээний хөтөлбөр, чамгүй олон сайт, мөн өдөр тутмын хоёр сонинд нэг ижил агуулга бүхий мэдээ гарсан явдал юм. Тухайлбал,

SBN: “Мобиком корпорацийг түрээсийн төлбөрөө төлөхийг шаардлаа, Мобиком корпорацийн удирдлагуудыг шалгуулахаар АТГ-т хандлаа”

MH25: “Мобиком корпораци компанийн түрээсийн мөнгөтэй холбоотой маргаан дэгдлээ”,

MNC: “Мобиком корпораци байрны түрээсээ төлөлгүй 5 сар болсон гэв”,

Zaluu.com: “Мобиком корпорац түрээсээ төлөлгүй 5 сар болжээ”

Medee.mn: “Мобикомын удирдлагуудыг АТГ-аас шалгахаар болжээ”

Dardas.mn: “Мобикомын удирдлагуудыг АТГ-аас шалгана”,

Sodonnews.mn: “Мобикомын удирдлагуудыг АТГ-аас шалгахаар болжээ”

Fact.mn: “Японы томоохон KDDI-н охин компани Монголын жижиг компанийг дээрэлхсэн үү”

Ene.mn: “Мобикомын удирдлагууд АТГ-т шалгагдана”

Murch.mn: “Мобиком корпорацийг түрээсээ төлөхийг шаардаж шаардлага хүргүүллээ”

Chuhai.mn: “Японы томоохон KDDI корпорацийн охин компани түрээсийн төлбөрөө өгөхгүй 5 сар болжээ”

shuud.mn: “Монгол, Японы хөрөнгө оруулалттай “Мобиком”-ын салбар компанийнхан шүүхэд дуудагдсаны учир”

grandnews.mn: “Мобикомын удирдлагуудыг АТГ-аас шалгахаар болжээ” гэсэн гарчигтай мэдээ гарсан.



Эдгээр мэдээлэл ёс зүйн зөрчилтэй гэж үзэн Мобиком корпорац ХМЗ-д гомдол гаргасан юм. Ёс зүйн хороо эдгээр гомдлыг хэлэлцээд редакциудын бэлтгэсэн мэдээ Ёс зүйн зарчмын **1.1** буюу “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”, **1.2** буюу “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ”, **1.6** буюу “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана”, **1.8** буюу “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно”, **4.2** буюу “Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан юм.

ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ

Ёс зүйн зарчмын **6-д** “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана” гэж заасан бөгөөд энэ заалт нь дотроо

6.1 - Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.

6.2 - Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.

6.3 - Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.

6.4 - Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.

6.5 - Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.

6.6 - Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.

6.7 - Амиа өгүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурьдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.

6.8 - Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй хэмээн 8 зүйл



болон задардаг. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч эдгээр дүрмээ баримталбал хохирогчийн хамгаалж чадна гэсэн үг.

2020-2021 онд 6-р заалтад хамаарах гомдол хэд хэд ирсэн нь анхаарал татаж байна. Тухайлбал, сураггүй алга болсон хэмээн эрэн сурвалжилж байсан бага насны хүүхдийг хэд хоногийн дараа хүчирхийлж, амь насыг нь бүрэлгэснийг олсон тухай мэдээлэхдээ хэд хэдэн редакц хохирогчийн зургийг гаргаж, нэрийг нь бүтнээр дурдаж, амьдарч байсан гэрийг нь харуулсан, нийслэлийн төв талбайд биеэ галдан шатаасан хүний талаар мэдээлэхдээ талийгаачийг танигдахуйцаар зургийг гаргасан, шатсан цогцосны хирдхийлгэсэн зургийг нийтэлсэн, өөрийгөө галдан шатааж байгаа видеог үзүүлсэн, залуус нэг нэгнээ хөнөөсөн байж болзошгүй хэргийг сурвалжлахдаа хохирогчийг танигдахуйцаар дүрсэлсэн, коронавирусийн халдвараар нас барсан талийгаачийн оршуулгыг ар гэрийнхэн нь зөвшөөрөхгүй гэж байхад телевизээр гаргасан зэрэг алдааг редакцууд гаргалаа.

Мэдээж дуулиант, олныг анхаарлыг татах хэргийг шуурхай сурвалжилж, шинэ баримт олох нь сэтгүүлчийн ажил мөн боловч хохирогчийг хамгаалах сэтгэхүйг эн тэргүүнд тавих учиртай.

БАЙЖ БОЛОМГҮЙ, БҮДҮҮЛЭГ АЛДАА

Мэргэжлийн ёс зүйд огт нийцэхгүй алдаа гаргах тохиолдол байна.

БАРИМТ

“Монгол нөхөртэй Япон бүсгүй Кикүчи Эрика: Жаахан царай, амт муутай болохоос биш бууз, цуйван хийчихнэ ээ” гэсэн мэдээ нэгэн сайтад хэвлэгдсэн. Гэтэл нь энэ нь өдөр тутмын нэгэн сонинд нийтлэгдсэн ярилцлагаас “босгосон” мэдээ байсан. Мэдээгээ бэлтгэхдээ ярилцлага өгсөн хүний талаар буруу ойлголт төрүүлэхүйц хэсгүүдийг тасдан авсан.

БАРИМТ

Эх сурвалжаас авсан ярилцлагаа хэсэг хугацааны дараа нийтлэхдээ ярилцлага авснаас хойш өрнөсөн улс төрийн үйл явдалд тохируулан ярилцагчийн яриаг өөрчилсөн.



БАРИМТ

Нэгэн компанийн буруутай үйл ажиллагааны талаар сурвалжилга хийчихээд, компанийн удирдлагаас мөнгө нэхэж, мөнгө өгөхгүй бол хэвлэнэ гэж сүрдүүлсэн. Компани ХМЗ-д гомдол гаргасан. Компанийнхан мөнгө нэхсэн сэтгүүлчийн утасны яриаг бичиж авснаа нотолгоо болгож өгсөн. Энэ тохиолдол ХМЗ-д ирсэн гомдлуудаас хамгийн ноцтой ёс зүйн зөрчил болсон юм.

ЭЭРЭГ ХАНДЛАГА: ЗАЛРУУЛГА ГАРГАХ, УУЧЛАЛ ГҮЙХ

ХМЗ гомдол хэлэлцэж дүгнэлт гаргаж эхэлснээс хойших өнгөрсөн 7 жилийн хугацаанд гарсан эерэг хандлагын нэг нь редакцууд алдаагаа ухамсарлаж, залруулга гаргах, мөн уучлал гуйх соёлд суралцаж байгаа явдал юм. Жил ирэх тусам залруулга гаргах, гомдол мэдүүлэгчээс уучлал гуйх редакцын тоо нэмэгдэж байна. Гэхдээ залруулга гаргаж, уучлал гуйснаар тухайн гомдлыг хэлэлцэхгүй гэсэн үг биш юм. Ёс зүйн зөрчил байгаа бол зөрчсөн гэсэн дүгнэлтийг гаргана, харин олон нийтэд мэдээлэхдээ зөрчил гаргасан редакцын нэрийг дурддаггүй журамтай.

Баримт. 2021 оны хоёрдугаар сарын 28-ны өдөр нэгэн сайтад “Эмэгтэйчүүдийн жолоо барих эрхийг хасчихвал Улаанбаатар түгжрэлгүй болно” гэсэн гарчигтай нийтлэл гарсан. Энэ нийтлэлд эмэгтэй хүн жолоо барих чадвар муу учраас нийслэл хотын түгжрэлийн шалтгаан болж байгаа учраас жолоо барих эрхийг нь хасъя гэсэн агуулгыг илэрхийлсэн. Энэхүү нийтлэлд иргэнээс гомдол ирсэн юм. Редакц уг нийтлэлийг хамтын ажиллагааны хүрээнд өдөр тутмын сонинд гарсан нийтлэлийг эх сурвалжтай нийтэлсэн ч уг нийтлэлийн агуулга эмэгтэйчүүдийг ялгаварласан хэрэг мөн гэдгээ хүлээн зөвшөөрч уг нийтлэлийг мэдээллийн архиваасаа устгаснаа илэрхийлсэн. Гэхдээ залруулга гаргаагүй, зөвхөн архиваасаа устгасан. Залруулга гаргаж, уучлал гуйхгүй ингэж мэдээллийг архиваас устгах нь редакц алдаагаа ухамсарлаж байгааг илтгэж байгаа хэдий ч залруулга гаргах нь илүү ёс зүйтэй үйлдэл болох юм. Архиваас мэдээллийг устгах нь технологийн боломжийн хувьд цахим орчны хэвлэлийн редакциудад боломжтой, харин сонин, сэтгүүл зэрэг хэвлэмэл контент, мөн телевизээр цацагдсан контентын хувьд боломжгүй юм. Тиймээс редакцуудад ижил тэгш нөхцөл бий болгох үүднээс залруулга гаргах, уучлал гуйх хэлбэрийг алдаагаа залруулсанд тооцох нь зохистой хэмээн ХМЗ үзэж байна.



Мөн залруулга гаргана гэдгээ ХМЗ-д илэрхийлдэг ч залруулгыг хэзээ, ямар хэлбэрээр хийснийг хянах боломжгүй байгааг харгалзан, залруулга гаргаж, уучлал гуйснаа редакц ХМЗ-д ирүүлэх хариу тайлбартаа нотлох журмын өөрчлөлт шаардлагатай байгаа юм.

СЭТГҮҮЛЧИЙГ ДАВХАР ЯЛЛАХ ХҮСЭЛТЭЙ ГОМДОГЧИД БИЙ

Сэтгүүлч, редакцын бэлтгэн түгээсэн мэдээ, мэдээлэлд гомдол гаргаж байгаа зарим гомдогч давхар яллах хүсэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, ХМЗ-д гомдол гаргасан хэрнээ мөн хууль хяналтын байгууллагад давхар гомдол гаргадаг. ХМЗ-ийн Гомдол барагдуулах журамд хууль хяналтын байгууллагад гомдол нь давхар хянагдаж байгаа гомдлыг хууль хяналтын байгууллагын шийд гартал хэлэлцэхийг хойшлуулж болдог. Редакцын бэлдсэн мэдээ ёс зүйн зөрчилгүй, мэргэжлийн хэм хэмжээнд бэлтгэгдсэн нь тодорхой бол хойшлуулахгүйгээр ч дүгнэлтээ гаргах боломжтой. ХМЗ-өөр гомдлыг шийдүүлэх нь гомдогч тал асуудлаа цаг хугацаа алдахгүй хурдан шийдүүлэх, өмгөөлөгчийн зардал хэмнэх давуу талтайн дээр мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэх, цаашлаад хэвлэн нийтлэх эрх чөлөөг дээдлэх эерэг үр дагавартай. Сэтгүүлч, редакциятай холбоотой гомдлыг хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх практик нь сэтгүүлчдэд өөрийн цензурыг бий болгох, эрэн сурвалжилга хийх хүсэл эрмэлзлэлийг мохоох сөрөг үр дагавартай юм.

Мөн ХМЗ нь гомдлыг хувь сэтгүүлч дээр хамаатуулж хүлээж авдаггүй, тухайн мэдээллийг бэлтгэн түгээсэн редакцияд хаяглан гомдол авдаг нь мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд оруулж буй том хувь нэмэр юм.

Баримт. Нэгэн сайтад 2020 оны хоёрдугаар сарын 6-ны өдөр “Эрдэнэт үйлдвэрийн мөнгө ёолдоггүй ба дураараа дургигчид” гарчигтай эрэн сурвалжилсан материал нийтлэгдсэн. Уг нийтлэлд “Эрдэнэт” үйлдвэрээс зарласан түлш шатахуун нийлүүлэх тендерт оролцон ялсан “Сод Монгол” групп “Эрдэнэт” үйлдвэрийн удирдлагатай хавсран ажиллаж энэ тендерт ялсан тухай өгүүлсэн. Тухайн нийтлэл сэтгүүлч “Шилэн данс дээрх бодит гүйлгээ”, “Бараа материал худалдан авах тухай санал, үндэслэл” зэрэг бичгийн эх сурвалжуудыг баримт болгон ашигласан, түүнийгээ ч тодорхой дурдсан, хоёрт, энэ нийтлэлд хэт дэврүүлсэн, хөөргөсөн зүйл байхгүй, сэтгүүлч баримтын дагуу дүгнэлт хийсэн, сэтгүүлч мэдээллийг цуглуулж, олсон мэдээлэлдээ тулгуурлан ажилласан тул гомдогчийн үзсэн шиг “Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана” гэснийг зөрчөөгүй хэмээн үзсэн.

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛД ХЭРХЭН ГОМДОЛ
ГАРГАХ ВЭ?**



Хавсралт 2

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛД ХЭРХЭН ГОМДОЛ ГАРГАХ ВЭ?

Монгол улсын иргэн бүхэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн сэтгүүл зүйн бүтээл ёс зүйн алдаатай байна гэж үзвэл Хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол гаргах боломжтой. Гомдол гаргах үйл явц нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

1. www.mediacouncil.mn цахим хуудсаар нэвтэрч 2015 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимтай танилцана.
2. Ингэснээр дээрх ёс зүйн зарчимд туссан 10 мөрдлөгийн алийг нь тус бүтээл зөрчсөнийг гомдол гаргагч нягталж мэдэх болно.
3. Сэтгүүлчийн бүтээл ёс зүйн зарчим зөрчсөн байна гэж үзвэл www.mediacouncil.mn цахим хуудсаар нэвтэрч ороод цахимаар гомдол гаргах буланд хандаарай. Мөн иргэд ХМЗ-д өөрийн биеэр хүрэлцэн ирж гомдол гаргах боломжтой. Харилцах утас: 70000160


Гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Иргэн/байгууллагын ирүүлсэн гомдлыг ХМЗ-ийн ажлын алба хүлээн авна. Гомдлыг нягталж үзээд үндэслэлтэй эсэх, Ёс зүйн хороогоор хэлэлцэх боломжтой эсэхийг хороон дарга нартай зөвшилцөнө. Гомдлыг хүлээж авах эсэхийг гомдол гаргагчид мэдэгдэнэ. Хүлээж авсан тохиолдолд гомдол хаяглагдсан редакцтай холбогдож тухайн гомдлын агуулгатай холбоотойгоор хариу тайлбараа ирүүлэх боломжтойг албан ёсоор мэдэгдэнэ. Үүний дагуу хэвлэл мэдээллийн байгууллагаас тайлбараа ирүүлдэг. Тухайн тайлбар хоёр төрлийн утга агуулна. Нэг бол редакц ёс зүйн зарчим зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, алдаандаа уучлал хүсээд гомдлыг сайн дураар шийдвэрлэх саналтай байж болно. Түүнийг нь гомдол гаргагч хүлээн зөвшөөрвөл ХМЗ-ийн ёс зүйн хороо уг гомдлыг хэлэлцэлгүй хаадаг.

Эсвэл редакц бүтээлдээ ёс зүйн алдаа гаргаагүй тухай тайлбараа ирүүлнэ. Ийнхүү гомдол гаргагч болоод редакцын байр суурь зөрчилдөөнтэй болсон үед ХМЗ-ийн дэргэдэх ёс зүйн хорооны улиралд нэг удаа болдог хурлаар тэдгээрийг хэлэлцээд шийдвэр гаргадаг. Шийдвэртээ ХМЗ-ийн ёс зүйн зарчмыг тухайн редакцын бүтээл зөрчсөн эсвэл зөрчөөгүй талаар тодорхой үндэслэлээр тайлбарлаж дүгнэлтээ гаргадаг. Энэхүү дүгнэлтийг гомдол гаргагч болон редакцад хүргүүлнэ. Үүний дараа хорооны шийдвэрийг олон нийтэд мэдээлдэг.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛД ГОМДОЛ ГАРГАХ СХЕМ





6.3 Дүгнэлтийг үндэслэн хорооноос дараах хэлбэрийн шийдвэр дагалдан гаргана. Үүнд:

- 6.3.1 Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага ёс зүйн зарчим зөрчөөгүйг мэдэгдэнэ.
- 6.3.2 Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага гаргасан алдаагаа өөрөө залруулсан эсвэл уучлал гуйсныг мэдэгдэнэ.
- 6.3.3 Тухайн хэвлэл мэдээллийн редакц ёс зүйн зарчим зөрчсөнийг мэдэгдээд шаардлагатай тохиолдолд Хорооны зөвлөмжийг зарлана.
- 6.3.4 Дараах тохиолдлуудад/6.3.1 болон 6.3.3/ тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын нэрийг олон нийтэд зарлана. 6.3.2 тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын нэрийг зарлахгүй. Гомдол гаргагчийн нэрийг нийтэд зарлахгүй.

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС
ЗҮЙН ЗАРЧИМ БА ЗААЛТУУД**



Хавсралт 3

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ БА ЗААЛТУУД

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт

Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

Ёс зүйн зарчмууд	Удирдамж /тайлбар
<p>Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.</p>	<ol style="list-style-type: none">1.1. Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.1.2. Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ.1.3. Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, ишлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.1.4. Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй.1.5. Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.1.6. Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана.1.7. Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцын агуулгаас ялгаж тэмдэглэнэ.1.8. Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.1.9. Нийтлэж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.



<p>2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.</p>	<p>2.1. Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно.</p> <p>2.2. Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг худал хэлэх буюу хэлэхгүй байх, дарамтлах, айлган сүрдүүлэх, сэтгэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон тагнаж чагнахыг хамаатуулна.</p> <p>2.3. Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.</p> <p>2.4. Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна.</p> <p>2.5. Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.</p>
<p>3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.</p>	<p>3.1. Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал, шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ.</p> <p>3.2. Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.</p>
<p>4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.</p>	<p>4.1. Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.</p> <p>4.2. Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.</p> <p>4.3. Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.</p>



	<p>4.4. Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.</p> <p>4.5. Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.</p> <p>4.6. Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.</p>
<p>5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.¹</p>	<p>5.1. Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурдана.</p>
<p>6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.</p>	<p>6.1. Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.</p> <p>6.2. Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.</p> <p>6.3. Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.</p> <p>6.4. Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.</p> <p>6.5. Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.</p> <p>6.6. Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.</p>



	<p>6.7. Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.</p> <p>6.8. Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол, гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.</p>
7. Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.	
8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.	
9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.	Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана. ²
10. Сонгууль Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ. ³	

¹ ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар өөрчлөлт оруулав.

² ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нэмэлт оруулав.

³ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар нэмэлт оруулав.



Ашигласан эх сурвалжууд

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн 2015-2023 оны үйл ажиллагааны тайлан
- Хэвлэлийн эрх чөлөөний тайлан. 2018-2022 он. Глоб интернэшнл
- Монголын хэвлэл мэдээлэл -Өнөөдөр, 2023 оны тайлан
- Хэвлэл мэдээллийг хэн эзэмшдэг вэ? судалгаа 2016 он. Хэвлэлийн хүрээлэн
- “Олон нийтийн хэвлэл мэдээллийг улс төрөөс хараат бус байлгах нь” судалгаа 2020 он Г.Гүнжидмаа
- Улс төрийн болон иргэний эрх, эрх чөлөөний индекс Countries and Territories | Freedom House
- Хил хязгааргүй сэтгүүлчид ОУБ-ын Хэвлэлийн эрх чөлөөний индекс Index | RSF

